



2021 оны ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

ГАДААД ХУДАЛДААГХӨГЖҮҮЛЭХНЬ

Холбоо барих

Sugarsuren Bayanmunkh

Luxxanadu.com

Шангрила оффис 801 тоот

P : +976 99190782

E : info@luxxanadu.com

Хамрах хугацаа

Эхлэх хугацаа :

01.01.2021

Дуусах хугацаа:

31.12.2021

Нууцлалын мэдэгдэл

Энэхүү баримт бичгийг компанийн үйл ажиллагааны зорилгын хүрээнд, зөвхөн эрх бүхий талуудад зориулан гаргасан болно. Өөр зорилгоор ашиглах, олшируулан тараах, хувилж үл болно



ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

АГУУЛГА

БИДНИЙ ТУХАЙ

04

БИДНИЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА

06

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ӨРГӨЖИЛТ, ТӨЛӨВЛӨГӨӨ

07

ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨСӨЛ

08

ТӨСЛИЙН ТУХАЙ

09

ТӨСЛИЙН ХУГАЦАА

10

ҮР ДҮН

12

МЭНДЧИЛГЭЭ

2021 онд Дэлхий нийтээр цар тахалтай тэмцсэн, хүндрэл бэрхшээлийг хохирол багатайгаар даван туулахад чиглэсэн, томоохон сорилтын жил байлаа.

Манай компанийн хувьд дотоод бүтцийн хувьд томоохон өөрчлөлт, шинэчлэлт хийсэн цаг үе байлаа. Шинэ бүтцийн хүрээнд байгууллагын стратеги бодлого, үйл ажиллагааны хөгжүүлэлтийн ажлыг уян хатан, хөрвөх чадвар сайтай байх тал дээр анхаарч тасралтгүй сайжруулж, зах зээлд эзлэх байр сууриа тэлэх шаардлагатай ажлуудыг цаг тухай бүрт нь хангаж ажиллаж байна.

Бид цаашдаа нэгэн зууны бахдам түүхийг үргэлжлүүлэн шилдэг боловсон хүчин, ухаалаг үйлчилгээ, тохилог орчинг бүрдүүлэн, аж үйлдвэрийн дөрөвдүгээр хувьсгалтай хөл нийлүүлэн цахим шилжилтийг түүчээлэн хийж дэлхийд тэргүүлсэн таваарын экспортын компани болох зорилго тавин ажиллах болно.

Люкс занаду групп ХК

**"Бидэнтэй хамтран үнэ цэнийг бүтээе,
учир нь бидэнд амжилтанд хүрэх сайхан санаа байна"**

Бидний тухай

Люкс занаду групп ХК нь зах зээлд 20 гаруй жил үйл ажиллагаагаа явуулж байгаа олон жилийн түүхтэй компани юм.

Компанийн үндсэн үйл ажиллагаа нь гадаад худалдаа боловч эдийн засгийн нөхцөл байдлаас шалтгаалан гадаад зах зээлд төдийлэн амжилттай ажиллаж чадсангүй. Компанийн үйл ажиллагааг тасралтгүй явуул ахын тулд сүүлийн 5 жилийн хугацаанд туслах үйл ажиллагааны хүрээнд програм хангамжийн хөгжүүлэлтэнд анхаарлаа төвлөрүүлэн ажилласан. Төрийн байгууллага, яамдуудын мэдээллийн сан, датаг боловсронгуй болгох тендерт амжилттай шалгарч хүлээсэн үүргээ хангалттай сайн биелүүлсэн.

Харин энэ жил хийсэн бүтцийн томоохон шинэчлэлт хийж компанийн ирээдүйн үйл ажиллагааг гадаад худалдааг хөгжүүлэх чиглэлд ажиллахаар төлөвлөөгөө боловсруулан ажиллаж байна.



СТРАТЕГИ ЗОРИЛТ

Дэлхийд өрсөлдөх нэмүү өртөг шингэсэн, стандартын шаардлага хангасан бараа, таваарын нийлүүлэлтээр тэргүүлэгч аж ахуй нэгж болж Монголын уул уурхайн бус экспортын салбарын төлөөлөл болох нь бидний стратегийн зорилго юм.



БАЙГУУЛЛАГЫН ҮНЭТ ЗҮЙЛ

Бидний үнэт зүйл нэмүү өртөг шингэсэн уул уурхайн бус экспортыг нэмэгдүүлэх гэсэн эрмэлзлэл, итгэл үнэмшил юм. Бид дараах зарчмуудыг үнэт зүйлээ болгон бизнесийн үйл ажиллагаа өргөжүүлнэ.

- **Дэвшилтэд технологи** - Технологи бол бүтээгдэхүүний гарц болон боловсруулалтын хувийг нэмэгдүүлэх, тогтвортой өсөлттэй ашигтай ажиллуулах гол түлхүүр гэж үздэг.
- **Үйл ажиллагаа** - Бид үйл ажиллагаагаа тасралтгүй сайжруулах чиглэлээр үргэлж хичээл зүтгэл гаргаж ажиллана. Шат дараатайгаар үйлдвэрлэлийн цар хүрээг нэмэгдүүлж, ашигт ажиллагааг нэмэгдүүлэхээр ажиллана.
- **Чанар** - Чанар манай хамт олны ажил болон бидний үнэт зүйлд шингэсэн байх болно. Бид арвин их туршлага хуримтлуулж, бүхий л үйл ажиллагаагаа оролцогч талуудынхаа хүлээлтийг давсан чанартай бүтээгдэхүүн, үйлчилгээ үзүүлэн ажиллахад зориулна



ЗОРИЛГО



330
БЭЛТГЭН
НИЙЛҮҮЛЭГЧИД



50
ГАДААДЫН ХУДАЛДАН
АВАГЧИД



55
МЭРГЭЖЛИЙН
АЖИЛТАНУУД

2021 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Төлөөлөн удирдах зөвлөлийн баталсан 2021 оны бизнес төлөвлөгөөний гол зорилго нь уул уурхайн бус экспортын салбарын төлөөлөл компаниудыг нэгтгэж, тэдгээрийг нэгдсэн менежментээр хангахад чиглэсэн билээ. Энэ хүрээнд бид уул уурхайн бус экспортын төлөөлөл компаниудтай хийх хэлэлцээрээ амжилттай эхлүүлсэн.

2021 онд Ковид-19 цар тахлаас үүдсэн хүндрэлүүд манай улсын эдийн засаг, ААН-үүдийн үйл ажиллагаанд нөлөөллөө. Тухайлбал, дэлхийн дахинд үүссэн нийлүүлэлтийн сүлжээний хямрал гадаад худалдаа, экспортын чиглэлд зорин ажиллаж буй бидний үйл ажиллагааг доголдуулж, үйл ажиллагааны болон санхүүгийн гүйцэтгэл төлөвлөсөн түвшинд хүрэхэд саад болсон юм.

2021 онд Компанийн хувьцаа эзэмшигчдийн бүтцэд томоохон өөрчлөлт орж, стратегийн хөрөнгө оруулагчид компанийн хувьцааг эзэмшиж эхэлсэн. Компанийн нийтэд зарласан 82,871 ширхэг хувьцааг нийт 13 хувьцаа эзэмшигч эзэмшиж байгаа бөгөөд 2нөлөө бүхий хувьцаа эзэмшигчтэйгээр санхүүгийн жил дууслаа.

Люкс Занаду Групп ХК нь 2021 онд томоохон гэрээ хэлцэл хийхэд төвлөрч ажилласан ба гэрээ хэлэлцээр хараахан дуусаагүй тул борлуулалтгүй ажиллаа. Ирэх жилээс хэлэлцээрийн үр дүн гарч борлуулалттай ажиллах тооцоололтой байна. Компанийн эргэлтийн хөрөнгийн дүн 22.5 сая төгрөг. Үүнээс 2.9 сая төгрөг нь мөнгөн хөрөнгө ба 19.6 сая төгрөг нь дансны авлага байна. Эргэлтийн бус хөрөнгийн 32.3 сая төгрөгийн үндсэн хөрөнгөтэй. Нийт хөрөнгийн дүн 54.8 сая төгрөг. Нийт өр төлбөрийн дүн болох 14.7 сая төгрөг нь богино хугацаат өр төлбөр ба үүний 6.3 төгрөг нь дансны өглөг, 2.4 сая төгрөг нь НДШ-ийн өглөг, 6 сая төгрөг нь урьдчилж төлсөн орлого байна. Эздийн өмчийн хувьд өөрчлөлт байхгүй ба 6.3 сая төгрөг байна.

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨЛТ

Монгол улсын эдийн засгийн бүтцийг солонгоруулах уул уурхайн бус экспортын зорилгын хүрээнд хушны самар, мах, ноос, ноолуур болон арьс, шир зэрэг үнэ цэнэ бүхий тавааруудыг нэмүү өртөг шингээн олон улсад экспортлоно.



ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОН САНХҮҮЖИЛТ

Монгол улсын эдийн засгийн бүтцийг солонгоруулах уул уурхайн бус экспортын бүтээгдэхүүнүүдийг боловсруулахад шаардлагатай санхүүжилтын оновчтой бүтцийг тодорхойлох. Оновчтой бүтцийг хүрээнд хийгдэх ажлуудын төлөвлөгөөг боловсруулж, үйл ажиллагааг өргөжүүлэх суурь нөхцөл, боломжийг бүрдүүлнэ.



СУДАЛГАА ХӨГЖҮҮЛЭЛТ

Анхдагч түүхий эдийг боловсруулах үйлдвэрлэлийн технологийг шинжлэх ухааны түвшинд хөгжүүлж хамгийн үр ашигтай технологийг бий болгох. Судалгаа хөгжүүлэлтийг олон улсын стандартын түвшинд хүргэж, худалдан авагчдад чанар стандартын баталгаа, үнэ цэнийг тогтоох итгэлийг бий болгоно.



ХУШНЫ САМАР

Гадаад худалдааны хамгийн эхний ажил бол хушны самрын экспорт юм. Үйл ажиллагааны хүрээнд Монголын хушны самрын ууган компанийг худалдан авах хэлцэлийг эхний байдлаар амжилттай хийж гүйцэтгээд байна. Хэлцэлийг 2022 оны эхний улиралд багтаан дуусгахаар зорьж ажиллаж байгаа. Худалдан авах хэлцэл дууссанаар гадаад худалдааны суурь нөхцөл бүрдэнэ.



МАХ, НООС, НООЛУУР & АРЬС, ШИР ...

Гадаад худалдааны бэлтгэл ажлын хангагдаж хушны самрын экспортын оргил үе дуусахад, бий болгосон санхүүжилтын бүтэц, бэлтгэн нийлүүлэлтийн тогтолцоо, ноу-хау дээр суурьлан дараагийн боломжит түүхий эдийн экспортыг хэрэгжүүлнэ. Энэ нь мах, ноос ноолуур болон арьс, шир зэрэг хөдөө аж ахуйн түүхий эд байна.



МАРКЕТИНГ

Таваарын зах зээлд дээр тогтсон далд бизнесийн тогтолцоог хэрхэн өөрчилж буй үйл ажиллагааг ил тод байдлаар олон нийтэд таниулах. Олон нийтэд үүсээд буй сөрөг сэтгэгдэл, ойлголтыг залруулж олон нийтийн дэмжлэгийг олж авна. Мөн олон улсын зах зээлд Монгол брэндийг бий болгох маркетингийн ажиллуудыг идэвхжүүлнэ.

“

Монгол улсын эдийн засгийн бүтцийг солонгоруулах боломж нь уул уурхайн бус түүхий эдийг нэмүү өртөг шингээн олон улсын зах зээлд экспортлох юм

ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨСӨЛ

2022 онд гадаад худалдааг хөгжүүлэх хүрээнд дараах төслүүдийг шат дараатайгаар хэрэгжүүлнэ.



01

GREENPINE

ХУШНЫ САМРЫН ЭКСПОРТ //

Хушны самрын идээг 99.99% хүртэл боловсруулан Герман, Солонгос, АНУ-руу шууд экспортлоно. Одоогоор үйлдвэрүүд нь дунджаар 83%-ийн цэвэрлэгээтэй 2\$-10\$-р Хятад улс руу нэмүү өртөггүй экспортолж байгаа бол бид 99.99%-ийн цэвэрлэгээтэйгээр 23.5\$-р экспортлоно.



02

МАХ

МАХНЫ ЭКСПОРТ //

Махыг дулааны аргаар боловсруулан олон улсын стандартад нийцсэн бүтээгдэхүүнийг экспортонд гаргана. Энэхүү төсөл нь 2022 оны 4-р улиралаас хэрэгжиж эхэлнэ. Бид 2022 оны 4-р улирал хүртэл хушны самрын экспортыг үргэлжлүүлэх болон төслийн санхүүжилтын суурь бүтцийг бий болгоно.

“GREENPINE” ТӨСӨЛ



ТӨСЛИЙН ТУХАЙ

Монгол оронд ургадаг хушны самар нь сибирийн ойн хуш бөгөөд Монгол, ОХУ-д ургадагаараа онцлог юм. Мөн өөр нэг онцлог нь хуш мод нь 4-5 жилд нэг удаа их ургац өгдөг нийлүүлэлт хомс байх хамгийн том шалтгаан болж нийлүүлэгчдэд том давуу тал олгодог онцлогтой хамгийн үр ашигтай салбаруудын нэг юм. Монгол улс нь дангаараа дэлхийн нийт хушны самрын экспортын 30 орчим хувийг дангаараа хангадаг. Бид нь хушны самрын идээг 99.99% хүртэл бүрэн боловсруулсанаар эдийн засгийн асар том боломж бий болох юм.

ТӨСЛИЙН ЗОРИЛГО

Хушны самрын идээг 99.99% хүртэл боловсруулан нэмүү өртөг шингээн олон улсын зах зээлд гаргаж Монгол улсын эдийн засгийн бүтцийг солонгоруулах уул уурхайн бус экспортын нэмэгдүүлэх тэргүүлэх экспортын компани болно

ТӨСЛИЙН ЗОРИЛТУУД

Хушны самар боловсруулах жишиг үйлдвэр байгуулж засаглалын шинэ системийг нэвтрүүлж, дэвшилтэд технологид суурилсан эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэн олон улсын зах зээлд гаргаж, Монгол улсын хушны самрын зах зээлийг тогтолцоог шинэчлэж, ил тод сайн засаглалыг бий болгоно.

ҮР ДҮН

Байгалийн баялагыг дотооддоо бүрэн боловсруулж, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүнээр олон улсын зах зээлд өрсөлдөнө. Ингэснээр тогтвортой ажлын байр бий болох, уул уурхайн бус экспортоор бий болох нийт гадаад валютын нөөц нэмэгдэнэ.

“GREENPINE” ТӨСӨЛ

Энэхүү төсөл нь манай компанийн бүтцийн өөрчлөлтийн хүрээнд хийгдэх анхны төсөл бөгөөд нарийн төлөвлөгөө, судалгааны хүрээнд дараах үндсэн 4 үйл ажиллагааны дагуу явагдана. Энэ төслөөр компанийн гадаад худалдааны байр суурийг тогтоох болно.

STEP 1

ХУДАЛДАН АВАХ ХЭЛЦЭЛ ХИЙХ



Бид эхний байдлаар Монгол хушны самар боловсруулах 20 гаруй жилийн түүхтэй ууган компанийг худалдан авах хэлцэлийг амжилттай гүйцэтгээд байгаа бөгөөд 2022 оны 1-р улиралд багтаан худалдан авах хэлцэлийг холбогдох хууль, дүрэм журамд нийцүүлэх ажиллуудыг хийж гүйцэтгэнэ

STEP 2

БҮТЭЭГДЭХҮҮН БОЛОВСРУУЛАЛТ



2021 оны 10 сард 1,000 м2 бүхий шинэ үйлдвэрийг ашиглалтанд оруулсан бөгөөд цэвэрлэнээний цэхийн засварын ажил үргэлжилж байна. Үйлдвэр бүрэн ашиглалтанд оруулсанаар хушны самрын идээг 99.99% хүртэл бүрэн боловсруулах юм.

STEP 3

ЗАХ ЗЭЭЛИЙН ӨРГӨЖИЛТ



Гадаадын худалдан авагчидтай холбоо тогтоож хамтын ажиллагаагаа өргөжүүлнэ. Мөн чухал нэг зүйл бол олон нийтэд үүсэд буй сөрөг сэтгэгдэлийг арилгах маркетингийн компани ажлыг эхлүүлнэ. Үүгээр компанийн ойн нөхөн сэргээлтийн үйл явц, хушны самрын ач тусыг сурталчлах, жижиглэн борлуулалтын салбаруудыг нээн ажиллуулна.

STEP 4

ЭКСПОРТ




2021 оны байдлаар Герман улсын томоохон хоёр компанитай экспортын гэрээ байгуулаад байна. Мөн Өмнөд Солонгос улс руу анх удаа хөлдөөсөн хүнсний төрлөөр хушны самрын туршилтын борлуулалт хийсэн бол 2022 онд экспортын хэмжээг

- Герман улс руу 99.99%-ийн цэвэрлэгээтэй 40 тн хушны самрын идээ экспортлох
- Герман улс руу 99.99%-ийн цэвэрлэгээтэй 500 тн хушны самрын идээ экспортлох
- Өмнөд Солонгос улс руу 99.99%-ийн цэвэрлэгээтэй 40 тн хөлдөөсөн хушны самрын идээ экспортлох

ТӨСЛИЙН ХУГАЦАА

2022 оны бизнес төлөвлөгөөний хугацаанд нийт 2 төсөл хэрэгжүүлэх бөгөөд эхний 3 улиралд багтаан хушны самрын экспортын төслийг хэрэгжүүлж дуусна



01 // Худалдан авах хэлцэл

Бид эхний байдлаар Монгол хушны самар боловсруулах 20 гаруй жилийн түүхтэй ууган компанийг худалдан авах хэлцэлийг амжилттай гүйцэтгээд байгаа бөгөөд 2022 оны 1-р улиралд багтаан худалдан авах хэлцэлийг холбогдох хууль, дүрэм журамд нийцүүлэх ажиллуудыг хийж гүйцэтгэнэ.

Үүний тулд санхүү, хөрөнгө оруулалт болон хуулийн зөвлөх үйлчилгээ авч ажиллана. Худалдан авах хэлцэлийн хамгийн том ажил болох бизнесийн үнэлгээг 2 сарын дотор хийж гүйцэтгэнэ.

02 // Самар боловсруулалт

2021 оны 10 сард 1,000 м2 бүхий шинэ үйлдвэрийг ашиглалтанд оруулсан бөгөөд цэвэрлэгээний цэхийн засварын ажил үргэлжилж байна. Үйлдвэр бүрэн ашиглалтанд оруулсанаар хушны самрын идээг 99.99% хүртэлх цэвэрлэгээтэй бүрэн боловсруулах юм.

Үйлдвэр нь өдөрт 20 тн хүртэлх зэрлэг хуш модны самрыг хагас боловсруулан цөмөх хүчин чадалтай.

Харин цэвэрлэгээний цехийн хувьд өдөрт 2 тн /2 ээлжээр 4 тн/ хушны самрын идээг 99.99% хүртэл цэвэрлэх хүчин чадалтай юм.

03 // Хушны самрын экспорт

2022 оны эхний 9 сарын дотор нийт 1000 тн хушны самрыг 99.99% хүртэлх цэвэрлэгээтэйгээр боловсруулан Өмнөд Солонгос болон Герман улс руу экспортолно. Үүнд:

- 2022 оны 2 сард 40 тн самар Герман улс руу
- 2022 оны 6 сард 60 тн самар Герман улс руу
- 2022 оны 7 сард 250 тн самар Герман улс руу
- 2022 оны 8 сард 20 тн самар Өмнөд Солонгос
- 2022 оны 9 сард 20 тн самар Герман

04 // Махны төслийн бэлтгэл

Манай компанийн стратегийн үндсэн зорилго нь таваарын экспортын тэргүүлэгч компани болох билээ. Энэхүү зорилгынхоо хүрээнд үе шаттайгаар компанийн үйл ажиллагааг өргөжүүлж төрөл бүрийн таваарын үйлдвэрлэлийг эхлүүлэн ажиллана. Анхны төсөл нь хушны самрын идээний экспорт байсан бол 2 дах төсөл нь олон улсын стандартын дагуу боловсруулсан монгол малын махны экспортын төсөл байх юм. Хушны самрын төслийн бий болгосон санхүүжилтийн схем, төслийн бүтцийг ашиглан энэхүү төслийг хэрэгжүүлнэ.

**“Бид нэмүү өртгийн
сүлжээг бий болгоно”**



LUXXANADU.COM

АНХААРАЛ ХАНДУУЛСАНД БАЯРЛАЛАА

ADDRESS

Улаанбаатар,
Сүхбаатар дүүрэг,
1-р хороо,
Олимпийн гудамж,
19А-С, Шангила
оффис 801

PHONE

P : +976 99190782

WEBSITE

info@luxxanadu.com
www.luxxanadu.com

Нууцлалын мэдэгдэл

Энэхүү баримт бичгийг компанийн үйл ажиллагааны зорилгын хүрээнд, зөвхөн эрх бүхий талуудад зориулан гаргасан болно. Өөр зорилгоор ашиглах, олшируулан тараах, хувилж үл болно